



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 07 өдөр

Дугаар 1/49

Бэрх хот

2025 оны 2 дугаар ээлжийн цэрэг
татлагыг зохион байгуулж явуулах тухай

Монгол Улсын "Хот тосгоны эрх зүйн байдлын тухай" хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, "Цэргийн албаны тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 12.3, 13 дугаар зүйлийн 13.6 дах заалт, Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/509 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2025 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагыг 2025 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 16:00 цагаас Соёлын ордны спорт зааланд зохион байгуулсугай.

2. 2025 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагын товчоог дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Товчооны дарга: Э.Мягмарсүрэн (ЗАА-ны дарга)

Нарийн бичгийн

дарга: Б.Соёл-Эрдэнэ (ЗАА-ны Архив, бичиг хэргийн эрхлэгч)

Гишүүд: Б.Мөнбиш (Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

М.Мөнх-Эрдэнэ (Батноров сумын сум дундын
цагдаагийн тасгийн хэсгийн төлөөлөгч,
Цагдаагийн ахлах дэслэгч)

А.Алтанцолмон (ГТУА 42-р ангийн
Захирагч, Хошууч)

3. Цэрэг татлагын арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг товчооны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захирагчийн орлогч (Н.Бахыт)-д даалгасугай.

ЗАХИРАГЧ



Н.ЭНХЖАВХЛАН

232501049